

Ч.Оюунбилэг, Д.Ариунаа, Х.Ариунаа,  
Ш.Ариунчимэг, Ж.Ууганцэцэг

# ХӨГЖИМ

## V

Ерөнхий боловсролын сургуулийн  
5 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны  
зөвшөөрлөөр хэвлэв.

Долоо дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.  
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот  
2020 он

DDC  
371.32  
X-545

Хөгжим V: Ерөнхий боловсролын сургуулийн 5 дугаар ангийн сурах бичиг /Оюунбилэг Ч., ба бус; Ред. Эрдэнэтуяа Ц., -УБ. 2014. 68х

Энэхүү сурах бичиг нь "Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай" хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ [textbook@mecs.gov.mn](mailto:textbook@mecs.gov.mn) хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99973-69-71-0

## ГАРЧИГ

Нараа баясан угтъя .....	5	Эгшгийн эрэмбэ .....	37
Алтан навчис даараа юм уу .....	6	Эгшиглэгээ .....	38
Гэрэлт нарны хүүхдүүд .....	7	Мажор минорын хөг, хувиргалын тэмдэг	39
Бүүвэйн дуу .....	8	Ээждээ би хайртай .....	41
Хөгжилтэй наадаан .....	11	Хөх яргуй .....	42
Уулын горхи .....	12	Бага ангийн багшдаа баярлалаа .....	43
Уулын хааны агуйд .....	13	Нараа нааш ир .....	43
Хөгжимдье .....	14	Хавар .....	44
Навчис бүжиг .....	16	Таван эрдэнэ .....	45
Хун .....	17	Сэрсэн тал .....	46
Зохион найруулъя .....	18	Талд ургасан хус .....	47
Өөрийгөө сориорой .....	20	Солонго .....	48
Амар сайн уу шинэ жил минь .....	22	Бүжиглэе .....	49
Шинэ жилийн мэнд хүргэе .....	23	Вальс .....	50
Өвлийн өвгөн айсуй .....	24	Бүжиглэцгээе .....	51
Цасан охидын туулайн дуу .....	25	Хөгжмийн даруулууд .....	52
Тэмцэгчдийн марш .....	26	Гурвал эгшиг .....	55
Хэдгэнийн нисэлт .....	27	Дуулж аргадах нутаг .....	58
Тэмээчдийн уралдаан .....	28	Зээрд халзан .....	59
Хөгжимдье .....	29	Улаан туг .....	60
Хошин аяз .....	29	Сэлэмт бүжиг .....	61
Анхны хичээл .....	30	Хөхөө .....	62
Бүжиг .....	30	Яргуй дэлгэрлээ .....	63
Алчууртай бүжиг .....	31	Хадтай толгой .....	63
Ботго .....	32	Twinkle twinkle little star .....	64
Зохион найруулъя .....	33	Ёохор .....	65
Өөрийгөө сориорой .....	35	Полька .....	66
Хөгжмийн эгшиг .....	36	Зохион найруулъя .....	67

## ӨМНӨХ ҮГ

Хичээлийн шинэ жилийн баярын мэнд хүргэе! Хүүхдүүд ээ!

Сурагчид та бүхэн өмнө нь ноотоор дуулж, хөгжмийн зэмсгээр хөгжимдөж, хөгжмөөр хүний сэтгэл хөдлөл, бодол санааг хэрхэн илэрхийлдэг хийгээд аливаа дүр дүрслэл, агуулгыг илэрхийлэхийн тулд хэлбэр бүтцийн хувьд ямар ямар хэсгүүдээс бүрддэг тухай үзсэн билээ.

Энэ хичээлийн жилээс хөгжмийн хичээлээр олж авсан мэдлэгээ гүнзгийрүүлэн, хөгжмийн утга агуулгын нууцад нэвтэрч, амьдралын олон талын тусгалыг улам бүр мэдэрч ойлгоход суралцах болно. Сурах бичигт орсон дуулах, хөгжимдөх, сонсох, бүжиглэх зэрэг бүхий л үйлүүд нь эдгээр мэдлэг чадварыг олгоход чиглэгдэж байгаа юм.

Та бүхэн амьдрал, байгаль юмс үзэгдлийн утга учрыг хөгжмийн урлагаар дамжуулан улам бүр гүнзгий ойлгохын тулд хөгжим сайн сонсож, агуулгыг ойлгохыг хичээн, шамдан суралцах нь чухал юм.



ДУУЛЪЯ



СОНСЪЁ



ХӨЖИМДЬЕ



БУЖИГЛЭЕ



ЗОХИОН  
НАЙРУУЛЪЯ



## ДУУЛЪЯ

- Ноот бичлэгт ажиглалт хийж тусгайлан тэмдэглэсэн хэсгийг давтаарай.
- Дуулах царааг тодорхойлоорой.
- Дуулах дүрмээ санаж ноотоор дуулаарай.

Үг. Ө.Баасанжав

Ая.Т.Чимэддорж

### НАРАА БАЯСАН УГТЪЯ

#### Цовоо, сэргэлэн

У - лаан на - ран ур-ган манд - лаа Уу - лын о - ройг гэр-лээр чим- лээ  
 Ас - ралт сай - хан аав баяс- наа Энэ - рэлт сай - хан ээж баяс - наа өг-лөө-ний  
 зори-гоор ө - нөөг үд - нээ ө-нөө-гийн үйл-сээр мар-гаа-шийг уг - та - наа



Илчит наран урган мандлаа  
 Энхрий нутаг даяар гийлээ  
 Эрдэнэт номоор бид баясна  
 Эрдэмт сайхан багш баясна

Алтан наран урган мандлаа  
 Алсын бараа дэргэд ирлээ  
 Анд сайхан найз баясна  
 Ахан дүүсэг нөхөд баясна.



- Ноотоор дуулаад хэмнэлээр тогшоорой.
- Ялгаа нь юундаа байна вэ?

ур-ган манд - лаа үд- нээ үд- нээ уг - та - наа



Үг. О.Сундуй

Ая.Ц.Эрдэнэ

### АЛТАН НАВЧИС ДААРАА ЮМУУ

Тайван

Мө-чир мөч-рөө ор - хин Ал-тан нав-чис уна-лаа даа

Мөн-гөн цас-ны тү - рүү - чээс Ий - шээ тий - шээ гүйлд - лээ дээ


Ал - тан ал - тан нав - чис Ал - ган дээр минь буу - гаач

Нам-рын сал-хинд даар - сан Нав-чис бү-хэн ду - лаа - цаач

Бөн бөн өнхрөөд  
 Бөмбөрч цаашаа одлоо доо  
 Шарчин шарчин буугаад  
 Сандарч цаашаа яарлаа даа

Улбар улбар навчис  
 Улам улам дэгдлээ дээ  
 Ачлал нөмөр үгүлээд  
 Арван зүгтээ хийслээ дээ

Алтан алтан навчис  
 Алган дээр минь буугаач  
 Намрын салхинд даарсан  
 Навчис бүхэн дулаацаач



- Үсрэлттэй хэсэгт багшийнхаа гарын дохиог харж дуулаарай.

Мө-чир мөч-рөө ор - хин

- Эдгээр хэсгүүдийн хэмнэл адил ч үгийн хуваарилалт гурван өөр байгааг анхаарч дуулаарай.

уна-лаа даа

буу - гаач

гүйлд - лээ дээ



- Ноотыг ажиглаж дууны цараа, айзам хэмжээг тодорхойлоорой.
- Багшаа сонсоод ноотоор дуулаарай.
- Хоёр хоолойгоор дуулахдаа бусдыгаа сонсоорой.

Үг. Ш.Бадарч

Ая.С.Батболд

### ГЭРЭЛТ НАРНЫ ХҮҮХДҮҮД

Зу-ны бо-роо шиг баяс-га-лан - тай      Өн-гийн солон-го шиг и-нээмс-гэл-тэй


Жар-гал-тай Монго-лын са-руул өг - лөө      Жавх-лан-тай ца - гийн гэ-гээн ту - яа

Бид бол      түм-ний и-рээ - дүй      Гэ-рэлт нар-ны хүүх -дүүд-ээ



Уулын горхины шуугиантай  
Түмэн шувуудын жиргээтэй  
Жаргалтай Монголын нарлаг өглөө  
Жавхлантай маргаашийн үүрийн туяа

Анхилуун цэцгийн дэлбээтэй  
Азтай жаргалын ашдын заяа  
Монгол түмний алтан өглөө  
Маргаашийн бидний жаргалын туяа



- Хэмнэлийн онцлогийг ажиглаад ялгааг илэрхийлж, алга ташилтаар гүйцэтгээрэй.

Өн-гийн солон-го шиг и-нээмс-гэл-тэй

- Цэгтэй хэмнэл

- Синкоп хэмнэл

Бид бол түм-ний и-рээ - дүй

- Зогсоцтой хэсэг



- Багшийн дуулахыг анхааралтай сонсоорой.

Хөгжим заримдаа дан ганц аялгуунаас бүрддэг.



Тухайлбал: Монгол ардын дуунууд.

Гэхдээ хөгжмийн хамсраатай дуулах дуу элбэг тохиолддог.



Жишээ нь:

Дээд дэвсгэр шугамд бичигдсэн аялгууг та нар дуулж, харин багш доод дэвсгэр дэх гурвал эгшгүүдээр хамсран хөгжимдөх болно.

- Хоёр ноотны ээлжлэн солигдох давталтаар дууг гүйцээн дуулаарай.
- Аялгууны зураглал хийгээрэй.
- Ямар үйл хөдлөлийг илэрхийлж болох вэ? Ярилцаарай.
- Багшийн хамсран хөгжимдөхийг анхааралтай сонсож, дагаад дуулъя. Ямар өөрчлөлт гарсан бэ?

Ая.С.Тиличиева

### БҮҮВЭЙН ДУУ

**Тайван**

Дүү минь унт даа бүүвэй бүүвэй  
Одод нойрмог нүдээ анивчина

Номин цэнхэр шөнө айсуй  
Унт даа унт даа бүүвэй бүүвэй





- Хөгжмийн эгшгүүдийн хөдөлгөөнийг ажиглаарай.
- Ноотоор дуулцгаая.
- Ноотоор дуулахдаа аялгууны хөдөлгөөнийг гарын дохиогоор илэрхийлээрэй.

Маамуу нааш ир. (Нэг өнгө давтсан)



Анхны хичээл. (Өгсөх чиглэлийн хөдөлгөөн)



Би цэцэг тарьсан. (Давлагаа маягийн хөдөлгөөн)



Ботго. (Үсрэлттэй хөдөлгөөн)



Бидний мэдэх дууны аялгуу ийнхүү олон янзын чиглэл хөдөлгөөнөөс бүрдэг байна.



Аялгууны бүтэц бидний хэл яриатай төстэй. Тухайлбал, бид ямар нэг санааг өгүүлбэрээр илэрхийлдэг. Хэд хэдэн энгийн өгүүлбэрийг нийлүүлж, нийлмэл өгүүлбэр бүтээдэг шиг хөгжмийн аялгуу ч мөн, дотроо хэд хэдэн хэсгээс бүрддэгийг харж болно.

- Ноот бичлэгийг ажиглаарай.
- Хэдэн хэсгээс бүтсэн байна вэ?

маа - муу наа - шир ма-найд хоёу-лаа тог - лоё аав ээж хоё - рын авчир-сан тог-лоом бий шүү

I өгүүлбэр

морь у - наж дав-хи -яа ма-шин барьж яв - бя ном со - нин унш - яа но- гоон мо-доо тарь -яа

II өгүүлбэр

*Маамуу нааш ир дуунд:*

- Найзаа гэртээ урьсан,
- Хамтдаа хэрхэн тоглох тухайгаа хүүрнэсэн шинжтэй, хоёр хэсгээр илэрхийлсэн байна. Эдгээр хэсэг тус бүрийг “Өгүүлбэр” гэж нэрлэдэг.
- Чиний өмнө дуусгаагүй орхисон аялгуу байна. Яаж дуусгаж болохыг хэд хэдэн хувилбараар үзээрэй.
- Аль нь утга санааг ( өгүүлбэрийг ) бүрэн төгсгөж байна вэ?

Ба - яр - тай ба - яр - тай сай - н суу - гаа рай

Ай хө шинэ жил минь а - мар сайн уу шинэ жил минь







# СОНСЪЁ

Д.Кабалевский

## ХӨГЖИЛТЭЙ НААДААН

- Зургийн дагуу хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Аялгууны чиглэл хөдөлгөөнийг зураг дээрээс ажиглаарай.
- Зохиол хэдэн хэсгээс бүтсэн бэ? Аялгуунд давталттай хэсэг бий юу?
- Доорх ноот бичлэгийн хөдөлгөөний чиглэлийг тодорхойлоорой.
- Хөгжмийн зохиолын аль хэсэгт тохирох вэ?






УУЛЫН ГОРХИ



Ж.Чулуун (1928-1996)  
Нэрт удирдаач, хөгжмийн зохиолч,  
хөгжимчин

Хийл, төгөлдөр хуурт зориулсан энэхүү бүтээлдээ хөгжмийн зохиолч байгалийн үзэсгэлэнт сайхныг хөгжмийн хэлээр илэрхийлсэн юм. Уулын ширүүн урсгалт сэрүүн горхи үсчин дэгдэж, алсад одон замхрах мэт сэтгэгдлийг төрүүлдэг.

- Зураглалын дагуу хөгжмөө сонсоорой .
- Аялгууны шинж төрхийг тодорхойлцгооё.
- Шүлгийн утга агуулга, дүрслэл хөгжимтэй хэрхэн холбогдож байна вэ?



Ургаа чулуунд урсгал задарч  
Уулын горхи долгио цацна.

Хөгжмийн намуухан ая давтаж  
Хөлийн дор ус шуугина.





Э.Григ

### УУЛЫН ХААНЫ АГУЙД

- Зургийг ажиглан, хэмнэлээр тогшоорой.



- Зохиолын гол аялгуу дараах хэмнэлээр 18 удаа давтагдана.



- Аялгууны давталтыг зураглалын дагуу сонсоорой.
- Ялгаж тэмдэглэсэн хэсгүүдэд ямар өөрчлөлт гарсан бэ?

1 2 3 4 5 6 7 8 9

10 11 12 13 14 15 16 17 18

Хурдасна 9

Маш хурдан 13

- Эгшиглэх хүч зохиолын явцад хэрхэн өөрчлөгдөж байгааг зургаас ажиглаарай.
- Тохирох хүчдэлийн тэмдгийг дарааллуулан байрлуулаарай.



1 2 3      4 5 6 7      8 9 10 11 12      13 14 15 16 17 18

*pp*      ?      ?      ?



## ХӨГЖИМДЬЕ

### Дасгал 1

- Ноот бичлэгт ажиглалт хийж, аялгууны ижил ба ялгаатай хэсгүүдийг олоорой.
- Ноотоор хөгжимдөж аялгууны чиглэлээр зураглал гаргаарай.

ца - гаан баав - гайн бамба-рууш тог - лон наа - даж байна

цэ - гээн туй - лын мө-сөн дээр бөм-бөг бит -гий ха - яа - рай

Аялгууны хэсгүүд давтагдаж байна.

### Дасгал 2

- Ноот бичлэгийг ажиглаад аялгууны чиглэл хөдөлгөөн, хэмнэлийг тодорхойлоорой. Аялгуунд давталттай хэсэг байна уу?
- Ноотыг хоёр хоолойгоор хөгжимдөөрэй. Хөгжимдөхдөө бие биеэ анхааралтай сонсоорой.


Аялгууны чиглэл хөдөлгөөн, хэмнэлийн зураглал өөр өөр өндөрлөгт давтагдаж байна. Зэмсгүүд харилцан ярилцаж байна.




### Дасгал 3

- Хөгжмөө анхааралтай сонсоод, ноотоор хөгжимдөөрэй.
- Хөгжимдөх явцдаа дараах гурван хувилбар юугаараа адил болохыг ажиглаарай.
- Хувилбаруудад чухам юу өөрчлөгдсөн бэ?


#### Хувилбар



#### Хувилбар



#### Хувилбар



Аялгууг хэвээр нь хадгалж, харин айзам хэмжээ, хэмнэлийг өөрчлөн дахин давтсан байна.





## БҮЖИГЛЭЕ

### НАВЧИС (хөгжимт хөдөлгөөн)

- Зургийн дагуу хөдөлгөөнийг дуурайн хийж сураарай.
- Өөрийн төсөөллөө аялгууны шинж төрхтэй холбон хөдөлгөөн зохиомжлоорой.



Намар болж  
Навчис сэрчигнэнэ.



Намуухан шаргал навчис  
Нарны туяанд бүжиглэнэ.



Салхинд наадан хийсэх  
Шаргал навчис минь бүжээрэй.



Зүггүй шаргал навчис минь  
Зүг бүрт хийсээрэй.



Эргэлдэн эргэлдэн бүжих  
Энэ навчсыг дуурайгаарай.



Салхины аясаар доошилсоор  
Сүүлчийн навчис минь уналаа.







## ХУН (гарын дасгал)

- Хөгжмийн дүр дүрслэлийг хөдөлгөөнөөр илэрхийлцгээе.
- Хоёр гарын хөдөлгөөнөөр хун шувууг дүрслэн тоглоё.



1. Хоёр гарыг дээш, доош зөөлөн хөдөлгөн, өөд өөдөөсөө харан хөвж буй хун шувууг дүрсэлнэ.



2. Хоёр гарыг ээлжлэн огцом эргүүлж, хун шувуу хүзүүгээ эргүүлэн ийш, тийш харж буй хөдөлгөөнийг дүрсэлнэ.



3. Хоёр гараа зэрэг аажмаар доошлуулан, хун шувуу толгойгоо нийлүүлэн тонгойж буй хөдөлгөөнийг дүрсэлнэ.



4. Хоёр гараа дээш, доош зөөлөн хөдөлгөн, ар араасаа хөвж буй хунг дүрсэлнэ.



5. Хоёр гарын эрхий хурууг нийлүүлэн хуруунуудыг сарвуугаар хөдөлгөн, далавчаа сэгсэрч буй хун шувууг дүрсэлнэ.



6. Хоёр гарыг зөрүүлж бугуйгаараа дээш, доош зөөлөн хөдөлгөн, далавчаа дэвэн нисэж буй хун шувууг дүрсэлнэ.



## ЗОХИОН НАЙРУУЛЪЯ

### Дасгал 1

- Багшийн хөгжимдөхийг сонсоорой.
- Дараах эгшгүүд ямар сонсогдож байна вэ? Доорх байдлаар ангилаарай. Сонголтдоо ✓ гэж тэмдэглээрэй.



Сонсоход тааламжтай бус, нийцгүй


а. б. в. г.

Сонсоход тааламжтай, нийцтэй

а. б. в. г.

### Дасгал 2

- Хөгжмөө сонсоод машины дуут дохиог дуурайн дуулж тоглоорой.
- Машинуудын дуут дохиог ямар дуурьслаар ( нийцтэй , нийцгүй ) дүрслэн илэрхийлж байна вэ?



Хөгжмийн зохиолчид хөгжмийг онцгой, өвөрмөц өнгө аястай болгох гэж иймэрхүү нийлэмжгүй, таатай бус сонсогдох дуурьслыг ашигладаг юм.

### Дасгал 3

- Эгшгүүд хоорондоо ямар зайтай байна вэ?



Эгшгүүдийн хоорондын зай янз бүр байх бөгөөд түүнийг интервал гэнэ.



### Дасгал 4

- Өөрийнхөө дуулж чадах хамгийн дээд, доод эгшгийг багшийн тусламжтайгаар тодорхойлоорой.
- “Нараа баясан угтъя”, “Гэрэлт нарны хүүхдүүд” дууны ноотонд ажиглалт хийж, багтаамжийг тодорхойлоорой.
- Дараах хөгжмийн зэмсгийн даруулуудыг харьцуулан ажиглаарай.
- Төгөлдөр хуур хөгжим хэдий хэмжээний дуу авиа гаргаж чадах вэ?
- Харин царгил хөгжим түүнээс ямар ялгаатай байна вэ?



Хүний хоолой, хөгжмийн зэмсгүүд ч мөн адил өөр өөрийн дуурьсаж чадах эгшгийн багтаамжтай. Үүнийг цараа буюу диапазон гэдэг.



Морин хуурын цараа  
Бага октавын Фа ( f ) – II октавын Си бемоль (  $v^2$  )


Хүүхдийн хоолойн цараа  
I октавын до (  $c^1$  ) – II октавын фа (  $f^2$  )



Хүүхдүүд ээ ! Та нар өөрийнхөө хоолойн цараанд тохирох дууг сонгон дуулж сураарай. Хоолойн цараанд тохиромжгүй дуу дуулах нь хоолойн хөвчийг гэмтээдэг аюултай.

### Дасгал 5

- Өнгийн хуулга болон хулдаасны голыг ашиглан багшийн заавраар хөгжмийн зэмсэг бүтээгээрэй.
- Бүтээсэн хөгжмийн зэмсгээрээ дараах хэмнэлийг хөгжимдөөрэй.



## ӨӨРИЙГЭЭ СОРИОРОЙ

- Анхааралтай сонсоод ноот бичлэгийг ажиглаарай.
- Аль аялгуу чамд сонсогдож байна вэ? Үүнийг олохын тулд:
  - а. Хэмжээ (размер),
  - б. Аялгууны чиглэл хөдөлгөөн,
  - в. Эгшиглэгээний онцлогийг анхаарах хэрэгтэй.


1. a – moll




2. C - dur



- Ноотыг ажиглаарай.
- Зогсоц дээр алгаа ташаарай.



- Хэмнэлээр тогшоод тайлбарлаарай. Ямар хэмнэл вэ?
- Дээрх хэмнэлээс ямар ялгаатай байна вэ?




- Ноотоор дуулцгаая.



- Аялгууны чиглэл хөдөлгөөн, хэмнэлийн зураглалыг ажиглаарай.
- Эхний хоёр айзмын зүй тогтлоор 3, 5, 7 дахь айзмыг нөхөж бичээрэй.



- Ноот бичлэгийг ажиглаарай.
- I шугамын хэмнэлийг II шугамын хоёр дахь айзмаас эхлэн давтан бичээрэй.
- Эхний хэмнэлийг найз чинь бөмбөрөөр, харин II хэмнэлийг чи өөрөө дуут модоор хөгжимдөөрэй. Бөмбөрийн хэмнэлийн араас алдалгүй дагаж тоглоно. Зөөлөн тоглох нь сонсож мэдрэх, ойлгох боломжийг олгоно.
- Энэ тоглолтыг чинийхээр юу гэж нэрлэвэл тохиромжтой вэ? Ярилцаарай.



Ямарваа нэгэн аялгуу болон хэмнэлийг дуурайн хөөцөлдөн дуулж, хөгжимдөх аргыг канон гэдэг.

- Сонирхлоороо нэгдэн хамтлаг байгуулцгаая. Танай хамтлаг дуучин, хөгжимчин гурван гишүүнтэй байна.
- Ноот бичлэгийг ажиглаад тус бүрдээ бэлтгэл сургуулилалт хийгээрэй. Үүний дараа хамтран дуулж, хөгжимдөнө.
- Хамтлагаар дуулж хөгжимдөхөд бие биеэ сайтар сонсох нь хамгийн чухал гэдгийг санаарай.





## ДУУЛЬЯ

Үг.Ш.Сүрэнжав

Ая.Б.Цогоо

### АМАР САЙН УУ ШИНЭ ЖИЛ МИНЬ

Вальс


Ца - сан шир-хэг цай-руул - сан Ца - гаан мөн-гөн шө - нөөр

Цал - гим бая - раар бял - хуул - сан Ши - нэ жи - л мЭН - дэл - лээ

Ай \_\_\_ хө \_\_\_ шинэ жил минь а - мар сайн уу шинэ жил минь

Золтой сайхан учралаар  
 Зориг хүслийг тэтгэсээр  
 Золбоо хийморь сэргээсэн  
 Шинэ жил мэндэллээ


Нараа тойрсон дэлхийдээ  
 Наадам бүжгээ хөгжөөсөөр  
 Насаа нэмсэн шинэ ондоо  
 Найрсан цөмөөр золголоо.



- Тусгайлан тэмдэглэсэн хэсгийг анхааралтай ажиглаарай.
- Эгшиг хоорондын зайг ( интервал) тодорхойлоорой.
- Хөгжмийн энгийн зэмсэг ашиглан хэмнэлийн хамсраа хийж дуулаарай.

бял - хуул - сан Ши - нэ

Ай \_\_\_ хө \_\_\_





- Дууны аялгуу айзмын хэд дэх хувиас эхэлж байна вэ?
- Амьсгааг хэддүгээр хувь дээр авах вэ?
- Багшийг сонсоод ноотоор дуулаарай.

### ШИНЭ ЖИЛИЙН МЭНД ХҮРГЭЭ

We wish you a Mer-ry Christ-mas, We wish you a Mer-ry Christ-mas, We wish you a Mer-ry Christ-mas And a hap-py New Year! Good tid-ings we bring To you and your king Good tid-ings for Christ-mas And a hap-py New Year!

Oh bring us a figgy pudding  
 Oh bring us a figgy pudding  
 Oh bring us a figgy pudding  
 And a cup of good cheer  
 Good tidings we bring to you and your king  
 Good tidings for Christmas, and a Happy New Year.



- Тусгайлан тэмдэглэсэн хэсгүүд дэх эгшгийн үсрэлтийг зөв мэдэрч дуулаарай.
- Эгшгийн үсрэлтийг гарын хөдөлгөөнөөр илэрхийлээрэй. Хэдэн эгшгийн зайтай байна вэ?

We wish you a Mer-ry We wish you a Mer-ry for Christ-mas

Good tid-ings we bring To you and your





- Дууны үгийг зөв тод хэлж дуулаарай.
- Айзам хэмжээг ажиглан ярилцаад, тэмдэглэсэн хэсэгт хэмнэл болон эгшгийн үсрэлтийг анхаарч дуулаарай.
- Дахилт хэсгээс амьсгааны хуваарилалт өөрчлөгдөж байгааг анхаараарай.

Үг. Г.Баатарнум

Ая. Ц.Эрдэнэ

### ӨВЛИЙН ӨВГӨН АЙСУЙ

Цан хүү-рэг сав-суул-сан Цал буу-рал ө - вөө минь Тэ-вэр дүү-рэн  
 бэл-гээ үүр - сээр Тэнгэ-рийн ууд-маас нааш-лан ай - суй Айл бү - рийн  
 өр-гөөнд зоч-лоод Амт-тан бүх-нээр мя-лаал-га өр - гөнө дөө Тив дэл - хийн  
 хүн бү - хэнд тэ - нүүн сай - хан амьд - рал бэ - лэг - лэнэ дээ

Халиун бугаа хөлөглөсөн  
 Хайлган сэтгэлт өвөө минь  
 Шидэт таягаа дээдлэн тулсаар  
 Шижиртэх хязгаараас дөтлөн айсуй

Цасан хаялга будруулсан  
 Илбийн сахалт өвөө минь  
 Цасан охидоо хөгжөөн дагуулсаар  
 Үлгэрийн орноос хурдлан айсуй



Тэн-гэр-ийн ууд-маас нааш-лан ай - суй  
 тэн - үүн сай - хан амьд - рал бэл - эг-лэнэ дээ

Дээрх хоёр хэсгийн ялгааг олж ажиглаад зөв илэрхийлж дуулаарай.





- Цасан охидын туулайн дууны утга санаа, аялгууны шинж төрхийг ярилцаарай.

Үг. М.Цэдэндорж

Ая. Ц.Эрдэнэ

### ЦАСАН ОХИДЫН ТУУЛАЙН ДУУ


Дэвх-рэн-хэн дэг-дэн-хэн яв - дал-тай\_\_ Дэл -дэн - хэн дэл-бэн -хэн чих- тэй -хэн

8 Бонд - гор - хон бор-хон-хон туу - лай минь\_\_ Ца -гаа - хан чан -дага-хан туу-лай минь

16 Бут - наа - саа бул-тан-хан ир - ээ - рэй\_\_ Дэрс - нээ - сээ

22 дэг - дэн -хэн ир - ээ - рэй\_\_ ир - ээ - рэй\_\_

Айлгамаар амьтанхан алга шүү  
 Үргээмээр үйлтэйхэн үгүй шүү  
 Хөтлөлцөөд хөгжилдөх хүүхдүүд байна  
 Барилцаад баясах багачууд байна  
 Туулай минь туулай минь ирээрэй  
 Тухтайхан тавтайхан шинэлээрэй



- Дараах хэмнэлээр тогшоорой.
- Хэмнэлүүдийн ялгааг олж тогтоогоорой.

Бадгийн хэмнэл



Дахилтын хэмнэл





# СОНСЪЁ

Ж.Фужик

## ТЭМЦЭГЧДИЙН МАРШ

- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Зэмсгүүдийн зургийг ажиглаад, сонсож таниарай.
- Зураглалын дагуу хөгжмөө сонсоорой.
- Цохилтын тоогоор зөөлөн тогшоорой.

8 | 16 | 2 - Энэ бол цохилтын тоо.



Сонсоорой.

8 цохилт

8

8

Нарийн бүрээ



Хэмнэлээр тогшоорой.

16 | 16 | 16 | 16

Татах бүрээ



Хэмнэлээр тогшоорой.

16 | 16 | 16 | 16

Их бүрээ

2 2 2 2



Холбоос ая

Лимбэ/флейт



Хэмнэлээр тоглоорой.

16 | 16 | 16 | 16

Татах бүрээ



8 | 8 | 4

Найрал хөгжим



16 | 16 | 16 | 16



Н.А.Римский – Корсаков

## ХЭДГЭНИЙН НИСЭЛТ

- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Хөгжмийн зохиолч хэдгэнийн нисэлтийг дүрслэхдээ ямар хэмжээтэй ноотыг хэрэглэсэн бэ?
- Хөгжмөө сонсонгоо эгшиглэх хүчийг тодорхойлоорой.
- Ноотыг ажиглаад эгшгийн хөдөлгөөнийг ярилцаарай.
- Хэдгэнийн нисэлтийг хөгжимд хэрхэн дүрсэлснийг зураглаарай.



Үлгэрт алс хол хүнгүй арал дээр цөлөгдсөн хунтайж Гвидон хэдгэнэ болон хувираад эх нутаг, хаан эцэг рүүгээ нисэж байгаа тухай гардаг. Хөгжмийн зохиолч хэдгэнийн нисэлтээр баяр хөөрөөр бялхан, урагш яаран тэмүүлсэн Хунтайжийн сэтгэлийн өнгө аяс, хөөр догдлолыг давхар илэрхийлжээ.

- Хэмнэлээр жигд хөгжимдөөрэй.
- Урагш яаран тэмүүлэх сэтгэлийг ямар хурдаар илэрхийлсэн бэ?
- Presto гэж ямар хурд вэ?






### ТЭМЭЭЧДИЙН УРАЛДААН

- Монгол уртын дуу “Өнчин цагаан ботго”- ыг сонсоорой.
- Ямар сэтгэгдэл төрсөн бэ?
- “Тэмээчдийн уралдаан” зохиолыг сонсоцгооё. Өмнөх зохиолоос ямар ялгаатай байна вэ?



- Доорх харьцуулалтыг ажиглаарай.
- Тэмээчдийн уралдааныг дүрслэн хэмнэлээр хөгжимдөөрэй.



Хөгжмийн дүрслэл илэрхийлэлд хэмнэл, хурд, хүч чухал үүрэг гүйцэтгэдэг ажээ.



## ХӨГЖИМДЬЕ

### Дасгал 1

- Ноотоор хөгжимдөөрэй. Аялгуу нь утга санаагаа илэрхийлж бүрэн төгссөн сэтгэгдлийг төрүүлж чадсан уу? Хэрэв үгүй бол хөгжимдөөд аялгууг төгсгөөрэй.



Хөгжмийн аялгуунд түүний утга санааг бүрэн төгсгөж чаддаг гол тулгуур эгшиг байдаг. Түүнийг тоник гэнэ.

И.С.Бах

## ХОШИН АЯЗ

### Дасгал 2

- Хөгжмөө сонсоод хэмнэлээр хөгжимдөөрэй.
- Хоёр гараа өвдөг дээрээ авч хэмнэлээр цохих, эсвэл доорх хөгжмийн энгийн зэмсгүүдийг ашиглаж хөгжимдөөрэй.





### Дасгал 3

- Ноотоор хөгжимдөөрэй. Эгшгийн цуваа болон үсрэлттэй хэсгийг анхаараарай.

Д.Оюунтүлхүүр

### АНХНЫ ХИЧЭЭЛ

Хурдавтар, хөнгөн

- Бүжгийн хөнгөн цоглог шинж төрхийг илэрхийлэн хөгжимдөхөд анхаараарай.

Ж. Оффенбах

### БҮЖИГ





## БҮЖИГЛЭЭ

### АЛЧУУРТАЙ БҮЖИГ (хөгжимт хөдөлгөөн)

- Зургийн дагуу хөдөлгөөнийг дуурайн хийж сураарай.
- Аялгууны шинж төрх, өнгө аясад тохируулан хөдөлгөөн зохиомжилж бүжээрэй.



Баруун гараа чичигнүүлэн голын жирэлзээг үүсгээрэй.



Алчуураа хоёр тийш хөдөлгөн голын урсгалыг илэрхийлээрэй.



Алчуураа наймын тоо эргүүлж усны долгион үүсгээрэй.



Алчуураа дээш хөөргөн далайн давлагааг дүрслээрэй.




Далайн усны цалгиаг дүрслээрэй.





## БОТГО (хөгжимт хөдөлгөөн)

- Хөгжмийн аялгууны хэмнэл, шинж төрхөд тохируулан ботгоны хөдөлгөөнийг дүрсэлж тоглоорой.



Ботгоны зөөлөн зөөлөн алхах хөдөлгөөнийг дүрсэлж, өвдгөө өндөр өргөн, толгойгоо дээш доош хөдөлгөн, алхаарай.



Ботгоны тоглон наадах, хөлөөрөө газар малтах хөдөлгөөнийг дүрслээрэй.



Хөлийг зөрүүлсэн байдлаас хоёр тийш ээлжлэн хаялж, ботгоны тэших хөдөлгөөнийг дүрсэлнэ.

Ботго ар араасаа цуварч хөнгөн алхаагаар тэшинэ.






## ЗОХИОН НАЙРУУЛЪЯ


Бидний харилцааны гол хэрэглүүр бол үг яриа мөн. Бид асуух, анхааруулах, нэрлэх, тоочих, амьсгаа авах зэргээр яриан дундаа түр зогсдог.

Үүний нэгэн адил хөгжимд ч бас утга агуулгыг илэрхийлэхийн тулд түр зогсолт хийдэг. Хөгжмийн хэлэнд энэ агшныг зогсоц буюу “Пауз” гэдэг. Энэ түр зогсолт нь бидний мэдэх ноотны урттай адил хэмжээгээр хэрэглэгдэх бөгөөд тусгай тэмдгүүдээр илэрхийлдгийг бид мэднэ.



### Дасгал 1

- Зогсцын тэмдгийг ашиглан бодлого бодоцгооё.



### Дасгал 2


- Дараах аялгууг өгөгдсөн эгшгээс байгуулж бичээрэй.
- Бичсэнээ хоёр хоолойгоор дуулаад үзээрэй.
- Зогсцын тэмдгүүдийг ашиглаж хэмнэлийн хамсраа зохиогоорой.






### Дасгал 3

- Сурагч Анандын “Туулай” сэдэвт бүтээлийг ажиглаарай.
- Ноотны дэвсгэр шугам дээр доорх хэмнэлээр 4-6 айзам аялгуу зохиогоорой.
- Зохиосон аялгуугаа дуулж үзээд нэр өгөөрэй.



### Дасгал 4


- Доорх хэмнэлийн дасгалыг өөрийнхөөрөө баяжуулан гүйцээж бичээрэй.
- Сонирхлоороо хамтлаг болж сурсан дуундаа хэмнэлийн хамсраа хийж хөгжимдөөрэй.



## ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ

### ХЭМНЭЛИЙН ЦАГ

- Хэмнэлийн дасгалыг алга ташилтаар болон хөгжмийн энгийн зэмсгүүдээр гүйцэтгээрэй.
- Хоёр багт хуваагдан нэг нь 12 цагаас, нөгөө нь 6 цагаас нар зөв тойрч хэмнэлээр хөгжимдөнө.
- Дараа нь хэмнэлийг өөрийнхөөрөө баяжуулан хөгжимдөөрэй.



- Өгөгдсөн чиглэлийн дагуу дөрөвт ноотоор интервал байгуулаарай.
- Байгуулсан интервалаа дуулаад үз.
- Энэ ямар дуу вэ?




↘ 3 ↗ 4 ↘ 2 ↘ 5 ↗ 2 ↗ 2 ↘ 2 ↗ 4 ↘ 3 ↘ 3 ↗ 2



## ДУУЛЬЯ

### ХӨГЖМИЙН ЭГШИГ

Бидний хүрээлэн буй орчинд олон янзын чимээ байх ба хүн сонсох эрхтнээрээ дамжуулан маш олон дуу авиаг хүлээн авч сонсдог. Тэр бүгдийг ердийн авиа буюу шуугиан, хөгжмийн дуу авиа гэж хоёр ангилдаг. Шуугианы өндөр, намыг тодорхойлох боломжгүй байдаг. Харин хөгжмийн дуу авиа нь дуурайн дуугарч болох тодорхой өндөртэй, чанга зөөлөн болоод урт богинын ялгарамжтай, өвөрмөц эгшиглэнтэй байдаг. Иймээс хөгжмийн авиа эгшгүүдийн тусламжтайгаар хүмүүс ая зохиож, түүнийг нь бид дуулж, хөгжимддөг. Хөгжмийн эгшиг бол хөгжмийн хэлний хамгийн гол хэрэглүүр юм. Хөгжмийн эгшгүүдийг дүрсээр тэмдэглэхээс гадна тоогоор бас үсгээр тэмдэглэдгийг та нар мэднэ.



- Ноотоор дуулаарай. Ямар дуу болохыг аав, ээж, багшаасаа асууж мэдээрэй.
- Ноотыг нэрлээд үсгээр тэмдэглээрэй.

#### Удаан





## ЭГШГИЙН ЭРЭМБЭ

Хөгжмийн эгшгүүдийг эхнээс нь дараалуулан ром тоогоор дугаарлая.

До	Ре	Ми	Фа	Соль	Ля	Си	Ля	Си	До	Ре	Ми	Фа	Соль
I	II	III	IV	V	VI	VII	I	II	III	IV	V	VI	VII

Ийнхүү дугаарласныг өрөг гэнэ. Өргийг ром тоогоор тэмдэглэнэ

Энд I өрөг ямар эгшиг байна вэ?

I өрөг До эгшиг байна.

Энэ цуваанд I өрөг До эгшгийг

Тоник гэнэ.

Тоник бол энэ цувааны хамгийн гол, тогтвортой эгшиг юм. Багшийнхаа тоглохыг сонсьё, бас дуулаад үзье.

Харин энд I өрөг ямар эгшиг байна вэ?

I өрөг Ля эгшиг байна.

Дараах эгшгийн цувааны хамгийн гол, тогтвортой эгшиг буюу тоникоор ямар эгшиг нэрлэгдэх вэ?

Сонсьё, бас дуулъя.



Ийнхүү эгшгүүдийг дэс дараалан дуулж хөгжимдөхийг эгшгийн цуваа буюу гамм гэж нэрлэнэ.

- До, ля тониктой эгшгийн эрэмбэ хоорондоо ямар ялгаатай сонсогдож байна вэ?
- Доорх харьцуулалтаас харцгаая.



Хөгжмийн эгшгүүд нь хоорондоо нарийн зохион байгуулалтад оршдог.




## Эгшиглэг

Мажор- Баяр баясгалан,  
золбоо хийморь бүрдсэн  
эгшиглэг


Минор- Уянгын болон  
уйтгар гунигийн өнгө аяс  
бүхий эгшиглэг

Мажорыг – dur, Минорыг – moll гэж тэмдэглэнэ.

### Мажорын эгшиглэг



### Минорын эгшиглэг



- Мажор, минорын эгшиглэгийг ноотоор дуулцгаая.

C - dur



A - moll



Хөгжим төгсөж буй санааг тоникоор илэрхийлдэг.




## Мажор минорын хөг, хувиргалын тэмдэг

### Фа мажорын хөг

Фа эгшгээс мажорын эгшиглэг байгуулж дуулья.

Ноот бичлэгийг ажиглаарай.

F-dur гамм



Фа эгшгээс эхэлж байгаа болохоор I өрөг буюу хамгийн тогтвортой эгшиг болох тоник нь Фа- F байна.

Энэ бол фа мажорын хөг.

Ноот бичлэгт  $\flat$  тэмдэг байна.



Энэ тэмдгийг бемоль гэж нэрлэнэ. (Зөөлний тэмдэгтэй ойролцоо дүрстэй) Си ноот байрлах шугаман дээр түлхүүрийн ард бичигдсэн байна. Иймээс си эгшгийг хагас өнгөөр доошлуулах үүрэг гүйцэтгэнэ.

Фа мажорын хөг си бемольтой.  
Фа мажорын тоник Фа.

Ноотоор дуулцгаая.

“Гацуурхан”



Аялгуу гэрэл гэгээтэй, хөгжилтэй байна. Энэ бол мажорын хөг эгшиглэг.

### Ре минорын хөг

Ре эгшгээс минорын эгшиглэг байгуулж дуулья.

Ноот бичлэгийг ажиглаарай.

d- moll гамм



Цомнолын I өрөг тоник нь ямар эгшиг байна вэ?

Энэ бол ре минорын хөг.

Ноот бичлэгт  $\flat$  тэмдэг байна.



Энэ тэмдгийг бемоль гэж нэрлэдгийг бид мэднэ. Мөн л си ноот байрлах шугаман дээр түлхүүрийн ард бичигдэж тухайн эгшгийг хагас өнгөөр доошлуулах үүрэг гүйцэтгэжээ.

Ре минорын хөг си бемольтой.  
Ре минорын тоник Ре.

Ноотоор дуулцгаая.

“Агсал”



Аялгуу уянгын зөөлөн эгшиглэнтэй байна. Энэ бол минорын хөг эгшиглэг.




## Мажор минорын хөг, хувиргалын тэмдэг

### Соль мажорын хөг

Соль эгшгээс мажорын хөг эгшиглэгийг байгуулцгаая.

Ноот бичлэгийг ажиглая.

G-dur гамм



I өрөг тоник нь юу вэ?

I өрөг буюу тогтвортой эгшиг тоник нь Соль- G байна.

Энэ бол соль мажорын хөг.

Бидний мэдэхгүй ямар тэмдэг байна вэ?



Энэ тэмдгийг диез гэж нэрлэнэ.

(Чагт хэлбэрийн дүрстэй )

Фа эгшиг байрлах V шугаман дээр бичигдсэн байна. Энэ тэмдэг эгшигийг хагас өнгөөр дээшлүүлэх үүрэгтэй.

Соль мажорын хөг фа диезтэй.  
Соль мажорын тоник Соль.

Ноотоор дуулцгаая.

“Начин шонхор хоёр”




### Ми минорын хөг

Ми эгшгээс минорын хөг эгшиглэгийг байгуулж дуулья.

Ноот бичлэгийг ажиглаарай.

e- moll гамм



I өрөг буюу тоник нь юу вэ?

Ми эгшиг-е

Энэ бол ми минорын хөг.

Чагт хэлбэрийн шинэ тэмдэг.



Хувиргалын тэмдэг диез ямар ноотны өмнө бичигдсэн байна вэ?

Мөн л фа эгшиг байрлах V шугаман дээр байрлажээ. Өөрөөр хэлбэл, фа ноотыг хагас өнгөөр дээшлүүлж дуулна гэсэн үг.

Ми минорын хөг фа диезтэй.  
Ми минорын тоник Ми.

Ноотоор дуулцгаая.

“Тэгвэл хоёулаа”




Ийнхүү мажорын цоглог бадрангуй, минорын уян зөөлөн хөг эгшиглэгийг өөр өөр ноотноос байгуулж, дуулж, хөгжимдөхөд хувиргалын тэмдгүүдийг ашигладаг юм байна.





Бемоль нь эгшгийг хагас өнгөөр доошлуулж байхад диез нь эгшгийг хагас өнгөөр дээшлүүлж байна. Энэ хоёр тэмдэг хоёулаа хөгжмийн эгшгийг хувиргах үүрэгтэй байгаа тул хувиргалын тэмдэг гэж нэрлэе.



- Дууны утга, санаа, аялгууны шинж төрхийг ярилцаарай.
- Ямар хөг эгшиглэг вэ? ( мажор, минор )


Үг. Ш.Шажинбат

Ая.3.Хангал

### ЭЭЖДЭЭ БИ ХАЙРТАЙ

Сарны цагаахан туяанд намайгаа  
Саатуулан бүүвэйлж ээж минь аялахдаа  
Эгшигт хорвоогийн үнэн сайхныг  
Эдэлж явахыг, эдэлж явахыг сургасан билээ

Амьдралын ариухан замаар намайгаа  
Алсын алс руу үдэж хоцрохдоо  
Ачлал хайрын нэхээгүй хариугаа  
Ард түмэндээ зориулахыг сургасан билээ



- Үгийн хуваарилалтыг хэмнэлд тохируулан хурц тод хэлж дуулаарай.
  - Мөр бүрийн эхний хэмнэлд үгийн хуваарилалт шахуу байгааг анхаараарай.
- Жишээ нь:

нар- ны ал - тан - хан за - маар  
нан-дин хай - раа - раа хө - төлж  
хү- ний орч - лон -гийн ү - нэн



- Ноот бичлэгийг ажиглаарай.
- Хэмжээ солигдож буйг анхаарч дуулаарай.
- Дууны утга агуулгыг ярилцаад ямар хөг эгшиглэгт (мажор, минор) бичигдсэн байгааг тодорхойлоорой.

Үг. Я.Балжир

Ая. Х.Сэргэлэн


### ХӨХ ЯРГУЙ

Хөнгөн, хөгжилтэй

Хөх яр - гуй нүд-лэх хав - раар Хөв-чин дэл-хий сэр-гэх ури- наар  
 Хө-хөө шу-вуу дон-го-дох дуу-наар Хүн бүх-ний бая-сах ца - гаар  
 Хөх яр - гуй хав - рын цэ - цэг Хүү-хэд бид-нийг бая-саа - наа  
 Хөг-жөө - нөө Хөх яр - гуй хөх яр - гуй хөх яр - гуй хөх яр - гуй  
 хөх яр - гуй Хүү-хэд бид - ний хөгж-мийн бая-рын дуу

Цэцэг цэцгийн эхэн манлай  
 Цэнгэлт зуны ирмүүн түрүү  
 Цэнхэр хөөрхөн яргуйг  
 Цэгээн тагтаа өргөн ниснэ

Хөх яргуй хаврын цэцэг  
 Хүүхэд биднийг баясаанаа, хөгжөөнөө  
 Хөх яргуй, хөх яргуй, хөх яргуй, хөх яргуй  
 Хүүхэд бидний хөгжмийн баярын дуу



- Дахилтаас хоёр хоолойгоор дуулахдаа нөхдийгөө сонсоорой.
- Хоёр хоолой ямар интервалын зайтай эгшиглэж байна вэ?

хөх яр - гуй Хүү-хэд бид - ний хөгж-мийн бая-рын дуу  
 3 ? ? ? ? ? ?



- Ноотоор дуулцгаая.
- Ноот бичлэгийг анхааралтай ажиглаарай. Ямар хөгт бичигдсэн байна вэ?
- Тусгайлан тэмдэглэсэн хэсэг дэх аялгууны эгшгүүд хөг эгшиглэгийн хэддүгээр өрөг байна вэ?

Үг. С.Бодоош

Ая. С.Батболд

### БАГА АНГИЙН БАГШДАА БАЯРЛАЛАА

Ү - зэг барь-сан турь-хан гарт минь \_\_\_ Үг хол-бох ар - гыг  
 I I III V  
 заа - сан \_\_\_ Бага ан - гийн баг-шаа бая - рал - лаа \_\_\_  
 Бал - чир - хан би чинь би - чиж сур - лаа. - тай \_\_\_  
 ? ? ? ? ?

I, III, V өргүүдийг тогтвортой эгшиг гэж нэрлэдэг.

- “Нараа нааш ир” дуунд II хоолой зохиоцгооё.
- Өгөгдсөн ноотноос доош тухайн интервалыг байгуулаарай.
- Зохиосноо дуулаад үзээрэй.

На - раа На - раа наа - шаа Сүү - дэр сүү - дэр цаа - шаа Най - заа  
 3 3 6 5 5 3 3 3 6 5 5 3 3 6  
 най-заа наа - шаа Нар - тай гур-вуул тог - лоё Нар - тай гур-вуул тог - лоё  
 4 3 3 5 3 6 4 3 3 5 3 6 4 3 6 6




## СОНСЪЁ

А.Вивальди

### ЖИЛИЙН ДӨРВӨН УЛИРАЛ (Хавар)

- Хөгжмөө зураглалын дагуу анхааралтай сонсоорой.
- Хавар хөгжмийн зохиолын утга санаа мөн “Яргуй” шүлгийн агуулгыг ямар эгшиглэгээр илэрхийлэх нь тохиромжтой вэ? Яагаад?
- Ямар зэмсгүүдээр хөгжимдөж байна вэ?
- Хөгжмийн зохиолч хаврын баяр баясал, шувуудын жиргээг илэрхийлэхдээ яагаад хийл хөгжмийн зэмсгийг сонгосон бэ?
- Хөгжмийн зохиолын хурд, эгшиглэлийн хүч ямар байна вэ?



Хөх яргуй нүдлэх хавар  
Хөвчин дэлхий сэргэх урин  
Хөхөө шувуу донгодох дуун  
Хүн бүхний баясах цаг...



Италийн суут хөгжмийн зохиолч А.Вивальди уянга тансаг хийл хөгжимд зориулан олон зохиол бичсэний хамгийн алдартай нь “Жилийн дөрвөн улирал” цуврал юм. Энэ зохиолд жилийн дөрвөн улирлын онцлог шинж, хувирал өөрчлөлт, өнгө төрхийг хөгжмийн хэлээр зураглан дүрсэлсэн байна.

Цомнол, аялгууны шинж төрх, хөгжмийн зэмсгийн эгшиглэлт, хөгжимдөх хурд, эгшиглэх хүч энэ бүхэн хөгжмийн зохиолын утга агуулгыг тодорхойлдог.



### ТАВАН ЭРДЭНЭ

- Зургийг ажиглаад хөгжмөө сонсоорой.
- Ямар мэдрэмж, сэтгэл хөдлөлийг илэрхийлж байна вэ?
- Хавар, Намар сэдэвт зургийн утга санааг хөгжмөөр илэрхийлэхэд ямар эгшиглэг тохиромжтой вэ?
- Аялгууны шинж төрх, хурд, хүч, өнгө аяс нь ямар байх вэ?



Энгэрийн яргуй цасан дор зүүдлэхэд  
 Эхний төл, наран наашилж цангинана  
 Эзэн малчны магнай тэнийн баярлаад  
 Эх орны минь сүрэг нэмлээ гэж дуулна.



Жилийн дөрвөн улирал өвөрмөц дүр төрх, өнгө аястай. Хүний зан авир, сэтгэл санаа, байгалийн үзэгдэл, өнгө аясыг хөгжмөөр илэрхийлэхэд хөг эгшиглэг чухал үүрэгтэй.



### “СЭРСЭН ТАЛ”

- Хөгжмийн зохиолыг сонсоод аялгууны шинж төрхөд тохирох үгсийг сонгон дэвтэртээ бичээрэй.

Яруу тунгалаг, хүйтэн зэврүүн, хахир хатуу, эрч хүч, баяр бахдал, бүүдгэр харанхуй, дулаан зөөлөн, хүнд бараан, гуниг харуусал, зоримог тэмүүлэл, бодол эргэцүүлэл, гэрэл гэгээ, хөгжил баясал

- Зураглалыг ажиглан зохиолын хэсгүүдийг үсгээр тодорхойлж бичээд, хурд, хүчийг тэмдэглээрэй.



www.google.com



www.google.com



www.google.com



Үндэсний найрал хөгжим




Гол аялгууг утсан хөгжмийн зэмсгүүд



Үндэсний найрал хөгжим

- Зохиолын хэсгээс ноотоор дуулж аялгууг төгсгөөрэй. Ямар эгшгээр төгссөн бэ? Түүнийг юу гэж нэрлэх вэ?
- Дуулахдаа гол аялгуунд хэмнэлийн хамсраа хийгээрэй.





## ХӨГЖИМДЬЕ

- Ноот бичлэгийг ажиглаад хөгжимдөөрэй.
- Аялгуунд давталттай хэсэг байна уу? Давтагдсан хэсгийг тэмдэглээрэй.

Орос ардын дуу

### ТАЛД УРГАСАН ХУС



#### Дасгал 1

Гурван хоолойгоор хөгжимдье. Үүний тулд:

- Ноот бичлэгийг ажиглаад хоолой тус бүрээр хөгжимдөнө.
- Бие биеэ сайтар сонсож зөөлөн хөгжимдөнө. Нэгдүгээр хоолойд гол аялгуу эгшиглэнэ.
- 4,8-р айзмыг ажиглаарай. Аялгуу хоёр болон гуравдугаар хоолойд шилжин төгсөж байна.

-  зураглал юу илэрхийлж байна вэ?



СОЛОНГО

- Хэмнэлийн  зураглалыг зөв илэрхийлэхийн тулд хэмнэлээр тогшиж үзээрэй.



Дасгал 2

- Тусгайлан тэмдэглэсэн хэсгийг ажиглаарай.
- Аялгуунд давталттай хэсэг байна уу? Тэмдэглээрэй.
- Хоёр хоолойгоор хөгжимдөөрэй. Хоорондоо хэдэн эгшгийн зайтай эгшиглэж байна вэ?







## БҮЖИГЛЭЕ

### АНГИЙН БҮЖИГ (хөгжимт хөдөлгөөн)

- Ая Л.Галмандах “Дэгдээхэй нас” дууны хэмнэлд тохируулан бие даан хөдөлгөөнөө сурсны дараа хосоороо бүжиглэж сураарай.



Баруун тийш 3 алхаад 4 гэхэд зүүн хөлөө өсгийгөөр тавина.

Эсрэг тал руу давтана.



Баруун зүүн хөлөө солбиж үсэрнэ.

Өвдгөө цохино.



Баруун гарын алгыг нийлүүлэн, зүүн хөлөө өсгийгөөр тавина.

Өвдгөө цохиод зүүн гарын алгыг нийлүүлэн, баруун хөлөө өсгийгөөр тавина.

Өвдгөө цохиод 2 гарын алгыг нийлүүлнэ.



## ВАЛЬС (Хөгжимт хөдөлгөөн)

-Хөгжмийн хэмнэлд тохируулан вальс бүжгийн хөдөлгөөнийг хосоороо хийж сураарай.



Бэлтгэх байдал



Хөвгүүд зүүн хөлөөс урагшаа, охид баруун хөлөөс хойшоо 1 2 3 гэсэн тоонд алхалт хийнэ.



Хөвгүүд охидын баруун гараас барин охид дорoo эргэлдэнэ.



Гар гараасаа барин урагшаа алхалт хийж ойртоно.



Хойшоо алхалт хийж холдоно.



Хөвгүүд зүүн, охид баруун гарын алгыг нийлүүлнэ.



Хоёр тийш зэрэг салж, гараа өргөж зогсоно.



Охид буцаж эргэн хөвгүүдийн урд зогсоно.



Хөвгүүд тонгойж, охид баруун хөлийг тавьж ёсолно.



## БҮЖИГЛЭЦГЭЭ (Хөгжимт хөдөлгөөн)

- Ая Л.Галмандах “Бага насаа хайрлаж явъя” дууны хэмнэлд тохируулан зургийн дагуу бүжиглээрэй.



Баруун зүүн хөл, гарыг ээлжлэн урагш алхалттайгаар тавьж, буцаад байрандаа зогсохдоо хоёр гарыг урдаа авна.



Хоёр гарыг урдаа авч хоёр тийш ээлжлэн харж, мөрөө урагш, хойш хөдөлгөх ба хөлийг өсгийгөөр тавина.

Баруун гарыг тохойгоор нугалан баруун хөлийг дээш нугалан үсрэлттэйгээр өргөнө. Эсрэг тал руу давтана.



Зүүн гар, баруун хөлийг солбиж хөлийг урагш шиднэ. Эсрэг тал руу давтана.

Баруун гарыг бугуйгаар эргүүлж, баруун хөлийг баруун тийш хавсарч алхана. Эсрэг тал руугаа давтана



Баруун гарыг дээш өргөж, зүүн гарыг биеийн дагуу авч дээш үсэрнэ.




## ЗОХИОН НАЙРУУЛЪЯ

### ХӨГЖМИЙН ДАРУУЛУУД

#### Дасгал 1



Төгөлдөр хуур хөгжим хар, цагаан маш олон даруултай. Түүний цагаан даруулууд нь хөгжмийн үндсэн 7 ноот буюу До, Ре, Ми, Фа, Соль, Ля, Си эгшгүүд. Харин хар даруулууд нь хувиргалын тэмдгийн тусламжтайгаар бий болсон үүсмэл эгшгүүд юм.

- Хувиргалын тэмдгийн тусламжтайгаар хар даруулуудыг нэрлэцгээе.



#### Дасгал 2

- Өгөгдсөн эгшгийг нэрлээд дэвсгэр шугамд болон хөгжмийн даруул дээр байрлуулаарай.



#### Дасгал 3

- Аялгуу зохиоцгооё. Ноот бичлэгийг ажиглаарай.
- Эхний айзмын аялгууны хөдөлгөөнийг дараагийн хоёр айзамд, тав дахь айзмын аялгууны хөдөлгөөнийг, мөн дараагийн айзамд өгөгдсөн эгшгээс давтаж бичээрэй. Энэ бол чиний зохиосон аялгуу болно.
- Зохиосон аялгуугаа дуулахдаа хэмнэлийг хурууныхаа өндгөөр зөөлөн тогшоорой.





### Дасгал 4

- Интервалыг зөв тодорхойлсон эсэхийг шалгаад, алдааг олж дэвтэртээ засаарай.

хөх яр - гуй Хүү - хэд бид-ний хөгж-мийн бая-рын дуу

3 3 2 6 3 4 3 4 1 1 4 1

### Дасгал 5

- Өгөгдсөн интервалыг байгуулаарай.
- Зөв байгуулж чадвал чиний сайн мэдэх дууны аялгуу үүснэ.
- Ноотоор дуулаад үзээрэй.

4 4 3 5 6 5

### Дасгал 6

- Өгөгдсөн интервалаар “Олуулаа” дуунд II хоолой зохиоё.
- Өөрсдийн найруулсан дууг дуулцгаая.


3 3 3 3 3 4 6 6 1

О - луу- лаа о - луу- лаа о - луу - лаа

### Дасгал 7

- Хөгжмийн даруул дээр тэмдэглэсэн эгшгийг дарааллаар нь дэвсгэр шугамд байрлуулаарай. Ингэхдээ өгөгдсөн хэмнэлээр бичээрэй.
- Зохиосон аялгуугаа дуулцгаая. Ямар дуу вэ?

2/4



Жишээ нь:

1 2 3 4



### Дасгал 8

- Чиний өмнө дуусгаагүй орхисон аялгуу байна.



### Дасгал 9

- Аялгууг хөнтрүүлж шинэ аялгуу зохиоцгооё.
- Дээрх аялгууг хөнтрүүлэн бичихийн тулд баримжаа болгон тэгш хэмт нэг цэгийг сонгох хэрэгтэй. Үүнд дэвсгэр шугамын аль ч шугам байж болно. Гэхдээ 3-р шугамыг сонгон авсан нь илүү тохиромжтой. Ингээд ноотондоо толь ойртуулан тусгая. Си ноот яг хэвээрээ бусад нь өөр байх болно. Эцэст нь аялгуу маань танигдахгүй болтлоо өөрчлөгдөнө. Туршаад үзье. Энэ бол чиний бүтээл.

### Дасгал 10

- Аялгууны чиглэл, хөдөлгөөнийг өөр өндөрлөгөөс давтаж бичээрэй.



### Дасгал 11

- Хөгжмийн эгшиг аялгууг дуулах, хөгжимдөх хүчийг илэрхийлдэг нэр томъёог зөв бичээрэй.

ME  O  R T E P  A  O  
 (чангаавтар) (зөөлөн)

T E P I  S S I   
 (чанга) (маш зөөлөн)


E Z  O  N O F  R T  S I M   
 (зөөлөвтөр) (маш чанга)



## ДУУЛЪЯ

### ГУРВАЛ ЭГШИГ

- Ноот бичлэгийг ажиглацгаая.  
Цуварч дуугарна. Зэрэг дуугарна.



Энэ бол гурвал эгшиг.

Гурвал эгшиг бидний дуулах дуунд нийцтэй сайхан сонсогдох хамсрааг бий болгож өгдөг. Та нарыг дуулахад багш тань эдгээр гурвал эгшгүүдээр хамсраа хийж хөгжимддөг.

- Дараах жишээг сонсьё, бас дуулъя.
- Чи ямар ялгааг олж мэдэрч байна вэ?
- Эгшиглэлтийн ялгааг олж сонсоорой.


Мажор



dur

moll

Минор



Мажорын гурвал эгшиг (аккорд) нь баяр бахдалтай, урам зоригтой, гэгээлэг сонсогддог.

Минорын гурвал эгшиг (аккорд) нь уян зөөлөн сонсогддог.



- C – dur, a – moll-ийн хөгт ноотоор дуулцгаая.

C- dur



a-moll



- Ноотоор дуулцгаая.
- Хөг эгшиглэгийг тодорхойлно уу. (мажор, минор)
- Аялгууны эхлэл, төгсгөл, хувиргалын тэмдгийг ажиглаарай.
- Дуулж, бас сонсоорой. Тогтвортой эгшиг аль нь вэ?
- Ямар хөгт бичигдсэн байна вэ?

### Гурвал эгшиг I, III, V



- Зогсоцтой хэсэгт II хоолой хэрхэн дуулахыг анхааралтай сонсоорой.











- Хөгжмийн даруул дээр тусгайлан тэмдэглэсэн эгшиг өгөгдсөн цувааны хэддүгээр өрөг болох вэ?
- Эгшгийн цувааг дуулаарай.
- Эгшгийн цуваанаас I, III, V өргийг дуулж, бас сонсоорой.
- Үүнийг юу гэж нэрлэх вэ?
- Сонссоноо дараах байдлаар ангилаарай.

№	Мажорын гурвал эгшиг	Минорын гурвал эгшиг
1		★
2		
3		
4		



- Хөгжмийн даруул дээр тэмдэглэсэн эгшгүүдийг дуулаад интервалыг тодорхойлоорой.
- Дуулж, бас сонсож тоглоорой.



Хөдөө тал минь



Туу-лай хаана унтдаг вэ?



Алтан навч хийслээ дээ



Алтан дэлхий



Хөх яргуй



Дэрсэнд хярсан



- Дууны утга санааг аялгуутай холбон ярилцаарай.
- Хоёр хоолойгоор дуулахдаа өөрийгөө болон бусдыг сонсоорой.

Үг. Ц.Чимэддорж

Ая. Г.Эрдэнэчулуун

### ДУУЛЖ АРГАДАХ НУТАГ



#### Хөнгөн

Ус\_ бид-нийг\_ мэл-мэрч хар-даг Уулс бид - нийг нам-саж хар-даг

5 Цаг ца - гийн-хаа ая-сыг да-гаад Цан-ги-нам ө - вөл\_ цаг-таа и- рээ - сэй

9 Э - вийн хор - воо-гоо ар - гад - сан Энэ-хэн\_ дэл - хий-гээ ө - рөвд - еө

13 И - жий аа - вын-хаа и - вээл хай-ранд Эл - гэн нут - гаа дээд-лэн хайр-ла-я

Алаг цэцэгс гундаж хардаг  
Агаар салхи анирлаж хардаг  
Усны шувууд удаж ирдэг  
Урин зун нь цагтаа л ирээсэй

Алтан элс нь шуурч нүүдэг  
Амьтны үрс нь айж төрдөг  
Намрын наран яарч буцдаг  
Навчис хүртэл эрт ганддаг



- Аялгууны эхний хэсгийн хэмнэлээр тогшоорой. Ямар хэмнэлүүд байна вэ?

Ус\_бид - шийг\_ мэл-мэрч хар-даг

- Хоёр дахь хэсгийг мөн хэмнэлээр тогшоод, ноотоор дуулаарай. Юугаараа ялгаатай байна вэ?

Уулс бид- шийг\_ нам-саж хар-даг



Ая. Х.Ягаанцэцэг

Үг. А.Шагдарсүрэн


### ЗЭЭРД ХАЛЗАН

Хурдан

Униарт сүлрэх цэнхэр нуурын  
 Уран цалгиат нутаг минь ээ  
 Ухаан бодолд янцгаан эргэцсэн  
 Уургын халзан морь минь ээ

Хуранд дэлгэрэх хөвч хангайн  
 Хуурын татлагат нутаг минь ээ  
 Хүслийн хязгаарт дэргэн хатирсан  
 Хүлгийн дээд морь минь ээ

Хүлгийн хийморьтой ажнай  
 Уран зээрд морь минь ээ  
 Зөөлөн гунигаар намайг аргадсан  
 Зүрхэнд эгшсэн нутаг минь ээ



- Тусгайлан тэмдэглэсэн хэсгүүдийг анхааралтай сонсож хэмнэлийг зөв илэрхийлээрэй.
- Үгийн хуваарилалтыг хэмнэлд тохируулан хурц тод хэлж, хөнгөн дуулна.
- Амьсгааны тэмдгийг анхаарч, хэмжээг гүйцэд барина.
- Холын үсрэлттэй хэсэгт багшийн гарын дохиог харж дуулаарай.



зэр - гэ - лээ наад - сан хөх уулс

зээрд хал - зан



## СОНСЪЁ

### УЛААН ТУГ



М. Дугаржав  
(1896- 1946 он)

- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Аялгууны шинж төрхийг тодорхойлоорой.
- Энэ зохиол дуу, бүжиг, маршийн аль төрөлд хамаарах вэ?

#### Марш

У - лаан ту - гийг\_ ман - дуу\_ лаад\_ Ул - сын\_

сү - рийг бад - руу - лаад У - рав - сан хул - гайн\_

дайс - нуу - дыг\_ Уу - хай\_ хий - гээд дарц - гаа - я



Ардын журамт цэргүүд анхныхаа тэмцэл ялалтыг магтаж, бадрангуй сэтгэл, хүсэл мөрөөдлөө илэрхийлсэн “Шивээ хиагт”, “Магнаг үсэгтэй туг”, “Улаан туг” дууг зохиосон билээ.

Улаан туг дууг ардын хувьсгалын үйл хэрэгт биеэр оролцож, шинэ Монголын соёлыг үүсгэн хөгжүүлэгч М.Дугаржав зохиожээ.

- Дууны үгийг тод дуудаж, аялгууг цоглог дуулахад утга агуулга нь улам тодорно. Энэ дууг дуулахдаа дараах хэмнэлээр бөмбөрийн хамсраа хийгээрэй.
- Хөгжимд тохирох хэмнэлийн хамсрааны хувилбарыг зохиогоорой.

*p* *mf*



### СЭЛЭМТ БҮЖИГ

- Армяны нэрт хөгжмийн зохиолч А.Хачатуряны “Сэлэмт бүжиг”-ийн хөгжмийг сонсоод хурд болон хүчдэлийн өөрчлөлтийг тодорхойлно уу.
- Зохиолд ямар хөгжмийн зэмсгүүд голлох үүрэг гүйцэтгэж байна вэ?
- Аялгууны шинж төрхийг шүлэгт хэрхэн дүрсэлсэн бэ?
- Хэмнэлийн зураглалыг шүлэгт хэрхэн дүрсэлсэн бэ?
- Хурц, цоглог бүжгийн шинж төрхийг илэрхийлсэн хэмнэлээр хөгжимдөөрэй.



А.Хачатуряны хөгжим нь цог жавхлант ардын бүжгийн хурц содон хэмнэлтэй бөгөөд гайхалтай урнаар оргилуун бадрангуй эгшиглэдэг.

Түүний ийм зохиолын нэг нь “Гаянэ” бүжгэн жүжгийн сэлэмт бүжгийн хөгжим юм.

Энэ хөгжмөөс гартаа хурц сэлэм барин гялалзуулж, бүргэдийн дэвэлтийг санагдуулан, өлмий дээрээ бүжих жавхаалаг эрчүүдийн бахдам дүр төрхийг төсөөлж болно. Уулаар нутагладаг ард түмний зоримог, хурц эрэмгий

зан төрх, дайчин шинжийг бүжгийн гялалзсан аялгуу, хурц тод хэмнэл улам тодотгож өгдөг.

Газар гижигдсэн гүрж бүжиг  
 Уулын голын догшин хэмнэлтэй  
 Тэнгэр цоргисон гүрж бүжиг  
 Нүд эсгэм хурц хөдөлгөөнтэй  
 (Б.Лхагвасүрэн. Гүрж бүжиг)

			Төгсгөл
Хурдан	.....?	.....?	



# ХӨХӨӨ

- Хөгжмөө сонсохдоо ноот бичлэгийг дагуулан харж, аялгууны зураглалыг ажиглаарай.
- Хөхөөний донгодолтыг ямар хөгжмийн зэмсгээр илэрхийлж байна вэ?
- Төгөлдөр хуур хөгжмийн ноот бичлэгийг ажиглаарай.
- Зураглалаас эгшгүүдийн хөдөлгөөнийг ажиглаад дагуулан зааж сонсоорой.
- Төгөлдөр хуур кларнет хоёр хэрхэн харилцаж байгааг ноот бичлэг болон зураглалаас харж ярилцаарай.

**Andante**



## ХӨГЖИМДЬЕ

### Дасгал 1

- Ноотоор хөгжимдөөрэй.
- Хөгжимдөхдөө тусгайлан тэмдэглэсэн хэсэг дэх эгшгийн үсрэлтийг анхаарч хурууны байрлалыг давтаарай.

Б.Цэвээнсүрэн

### ЯРГУЙ ДЭЛГЭРЛЭЭ

Тайван

### Дасгал 2

- Ноотоор хөгжимдөхдөө арван зургаат ноотны хэмжээг анхаараарай.
- Тусгайлан тэмдэглэсний учир вэ?

Монгол ардын дуу

### ХАДТАЙ ТОЛГОЙ

Удаавтар



### Дасгал 3

Ноот бичлэгийг анхааралтай ажиглаарай.

Хоолой тус бүрээр хөгжимдөөрэй. Нөхдөө сонсож багшийн дохиог анхаараарай.

### TWINKLE TWINKLE LITTLE STAR

The musical score is written in 4/4 time and consists of three systems of three staves each. The first system starts at measure 1, the second at measure 5, and the third at measure 9. The melody is in the top staff, and the accompaniment is in the middle and bottom staves. The score ends with a double bar line at the end of the third system.





## ЁОХОР (тойрон бүжиг)

- Аялгууны хэмнэлд тохируулан хөдөлгөөнөө хийж сураарай.



Тохойн чинээ газартаа  
Тойрон байж хатирья



Толгой дээрх гоёлоо  
Ханшир яншир хатирья



Эргэлдэн наадъя  
Элдвээр зугаалъя  
Мушгиралдан наадъя  
Мэддэгээрээ зугаацъя



## ПОЛЬКА (тойрон бүжиг)

- Хөгжмийн хэмнэлд тохируулан хосоороо тойрон бүжиг хийж сураарай.



Хөвгүүд охид өөд өөдөөсөө харан өсгий өлмий гэсэн дарааллаар хөлөө тавьж, зүүн тийшээ хавсралттайгаар үсэрнэ. Эсрэг тал руугаа давтана.



Хөвгүүд охид сугадалцан дороо үсэрч эргэлдэнэ.

Өвдгөө цохих, алгаа таших хөдөлгөөнийг хийнэ.




Охид хормойгоо барьж, хөвгүүд гараа ташаандаа авч баруун, зүүн тийш дороо эргэлдэнэ. Энэ тойрон бүжгийг сураад ангиараа хийх боломжтой.



## ЗОХИОН НАЙРУУЛЪЯ


### Дасгал 1

- Эгшгүүдийн хөдөлгөөн хаашаа чиглэж байгааг зургаас ажиглаарай.
- Зураглалын дагуу аялгуу зохиоё.
- Ноотонд шилжүүлж бичээрэй.
- Зүүн гарын хурууны дугаарыг баримтлан тоглож дуулаарай.



### Дасгал 2

- Зургийг ажиглаад алдааг олж илрүүлээрэй. Зөв хувилбарыг дэвтэртээ бичээрэй.



### Дасгал 3

- Өгөгдсөн үсгэн тэмдэглэгээний дагуу эгшгийн цувааг дуулж хөгжимдөөрэй. Эгшиглэх онцлогоор нь ямар хөг эгшиглэгээнд бичигдсэнийг тодорхойлоорой.

C D E F G A H

? moll

A H C D E F G

? dur



### Дасгал 4

- Өгөгдлийг тэмдэгтээр илэрхийлээрэй.

Чанга - ? Зөөлөн - ? Маш чанга - ? Соль түлхүүр - ? Диез - ?  
Бемоль - ? Чангаас зөөлрөх - ? Аяараас чангарах - ?

### Дасгал 5

- Өгөгдсөн эгшгээс уруудах хөдөлгөөнд гурвал эгшиг зохиоцгооё.

### Дасгал 6

- Өгөгдлийг ноотоор илэрхийлнэ үү.

Жишээ нь:

$1 - \frac{1}{2} =$

$5 - 3 =$

$3 - 2 =$   
 $1 + 1 =$   
 $4 - 2 =$

$6 - 2 =$   
 $8 - 4 =$   
 $3 - 2 =$